

Маргааны товч:

Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 0014100 дугаар шийтгэлийн хуудсаар “Миг даатгал” ХХК-д Зөрчлийн тухай хуулийн 11.13 дугаар зүйлийн 15.18-д зааснаар 5,000,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулжээ.

Гомдол гаргагчаас “... Санхүүгийн зохицуулах хороо нь даатгуулагчтай байгуулсан гэрээний эрх зүйн харилцаанд оролцох, даатгуулагчид нөхөн төлбөр олгох даалгавар өгөх шүүхийн эрхийг хэрэгжүүлэх эрхгүй. Иргэний эрх зүйн өмчийн харилцааны маргаанд Хороо нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу урьдчилан шийдвэрлэх журмыг хэрэгжүүлнэ, энэ нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3-т заасан ажиллагаа юм. Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн албан бичиг нь Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.10-т заасан даалгаврын шинж, хэлбэрийг агуулаагүй, албадлагын арга хэмжээ авах шийдвэр биш үзэж байна. Даатгуулагч салхины шилний зураас хаана үүссэн, юунаас үүссэн гэдгийг даатгагчид нотолж өгөөгүй, мөн тухайн эвдрэлд өмнөх осолтой холбоотой шинж агуулсан баримтууд байсан учраас даатгагчийн зүгээс нөхөн төлбөр олгох боломжгүй гэж үзсэн. Энэ талаар тайлбарласан албан бичгийг хариуцагчид хүргүүлсэн байхад “эрх бүхий байгууллагаас өгсөн даалгаврыг биелүүлээгүй” гэх үндэслэлээр шийтгэл ногдуулсан нь үндэслэлгүй ...” гэх агуулгаар маргасан.

Хариуцагч үүнийг эс зөвшөөрч “... Нөхөн төлбөрийг олгохоос татгалзаж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй, тухайн тохиолдол нь зам тээврийн осолд хамааралгүй, зөвхөн тээврийн хэрэгслийн салхины шилэнд учирсан хохирол байдаг. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалтыг үндэслэн даатгалын гэрээнд заасан эрсдэлийн улмаас даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг олгох асуудлыг урьдчилан шийдвэрлэж, хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдэгдэхийг даатгуулагчид үүрэг болгосон. “МИГ даатгал” ХХК нь Хорооны шийдвэрийг эс зөвшөөрч шүүхэд хандаж шийдвэрлүүлээгүй. Даатгуулагчийн эрх ашиг зөрчигдсөн байсан тул Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.10-т заасныг үндэслэн хуулийн хүрээнд шаардлагатай арга хэмжээг авсан. Зөрчлийн тухай хуульд зааснаар эрх бүхий албан тушаалтны зүгээс зөрчилд шийтгэл ногдуулсан нь үндэслэлтэй, улсын байцаагч эрх хэмжээгээ хэтрүүлээгүй. Гомдол гаргагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй ...” гэсэн агуулга бүхий тайлбар өгчээ.